



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019.04.15 № 3/1506
танай _____-ны № _____-т

Г АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА, ХАРЪЯА
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЗАХИРАЛ,
МОНГОЛЫН ЭРХИЙН АНАГААХ
УХААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН
ХОЛБОО, МОНГОЛЫН СУМЫН ЭМЧ,
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБООНЫ
ЕРЭНХИЙЛӨГЧ НАРТ

Г Тушаал хүргүүлэх тухай Г

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 2019 оныг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт– Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг онцлох жил” болгон зарласантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/149 дүгээр тушаалаар баталсан “БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОНЦЛОХ” жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлж байна.

Тушаалыг холбогдох албан тушаалтан, өрх, сум, тосгоны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Төлөвлөгөөг хавсаргав.

Хавсралт: 6 хуудастай.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Р.ОЮУНХАНД





МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 0/149.

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2019 оныг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт – Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг онцлох жил” болгосонтой уялдуулан Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/, Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/ -т тус тус даалгасугай.


3. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг 2019 оны 6 болон 12 дугаар сарын 25-ны дотор Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ



“БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОНЦЛОХ” ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 2019 ОН

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах газар	Хамтран ажиллах газар, байгууллага	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний хууль, эрхзүйн орчныг боловсронгуй болгох					
1.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлуулах	I улирал	БТГ	ЭТГ	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна.
2	Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах тухай журмыг боловсруулах	II улирал	БТГ	ЭТГ, МСЭМХ	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна.
3.	Монгол Улсын иргэн өрх, сум, тосгоны эмчийг сонгон бүртгүүлэх журмыг боловсруулах	II улирал	ЭТГ	БТГ, Нийгмийн ЭМГ МӨАУМХ, МСЭМХ	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна.
4.	Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний явцын болон гүйцэтгэлийн чанарын шалгуур үзүүлэлт боловсруулах	II улирал	ЭТГ	БТГ, Нийгмийн ЭМГ	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан байна.

5.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулах	II-IV улирал	ЭУТГ	БТГ, ЭТГ	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг СХЗГ-аар батлууна.
6.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний асуудлаархи Астанагийн тунхаглалыг анхан шатны тусламж үйлчилгээний бодлого, төлөвлөлтөд тусгах, сурталчлах ажлыг зохион байгуулах	I-IV улирал	БТГ	НЭМГ, ДЭМБ	Астанагийн тунхаглалыг орчуулж, хэвлүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт танилцуулна.
7.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, УИХ-ын НББСШУ-ны Байнгын хороонд санал, тооцоог хүргүүлэх	II улирал	ЭЗСХОГ	БТГ, ЭЗСХ	НББСШУ-ны Байнгын хороонд санал, тооцоог хүргүүлсэн байна.
Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах					
8.	Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой эрхзүйн баримт бичиг бодлогын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх	III улирал	БТГ	ЭТГ, Нийслэлийн ЭМГ, МӨАУМХ	Үнэлгээний тайлан гарсан байна.
9.	"Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн судалгаа" хийх	I-II улирал	ЭТГ	ЭУТГ, АШУУИС-ийн НЭМС	Судалгааны тайлан гарсан бай-а.
10.	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний дүнд хугацааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр 2020-2024 онд үийн үйл ажиллагааг төлөвлөж оруулах	I-II улирал	БТГ	ЭТГ, АХБ-ны Мастер төлөвлөгөөний төсөл	Бодлогыг хэрэгжүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна
11.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд үнэлгээ хийх аргачлалыг танилцуулах сургалтыг зохион байгуулах	I улирал	БТГ	ЭМДБХ	Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан байна.

12.	Хамтдаа суралцах сүлжээ байгууллагын боловсруулсан Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өөрийн үнэлгээний гарын авлагыг хэрэгжүүлэн, үнэлгээ хийх	I-II улирал	БТГ	ЭМДБХ ЭМДЕГ, аймаг, нийслэлийн ЭМГ	Үнэлгээний тайлан гарсан байна.
13.	ЭМАНШТУ-ний даатгалын санхүүжилтийн байдалд үнэлгээ хийж, өртөг, зардлыг тооцох	III улирал	ЭМДБХ	ЭМДЕГ	Үнэлгээний дүн гарсан байна.
14.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч нарыг эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад төрийн сангийн зардлаар сургах	II-IV улирал	ТЗУГ	ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ	300 эмч сургагдсан байна.
15.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр сургагч багшийн сургалт зохион байгуулах	II-III улирал	ЭТГ	ЭМХТ, АШУУИС, аймаг, нийслэлийн ЭМГ, ДЭМБ	150 сургагч багш бэлтгэгдсэн байна.
16.	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын байршлын зураглалын цомог гаргах	III улирал	БТГ	ДЭМБ	Байршлын зураглалын цомог гарсан байна.
17.	Эрүүл мэндийн салбарын (анхан шатны байгууллагуудад ажиллагсдын) хүний нөөцийн мэдээллийн санг цахимжуулах ажлыг эхлүүлэх	I-IV улирал	ТЗУГ,	ЭМХТ	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдээллийн сан бий болсон байна.
Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
18.	Дэлхийн эрүүл мэндийн өдрийг "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт – Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг онцлох жил" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх	4-р сар	Нийгмийн ЭМГ	Ажлын хэсэг, Нийгмийн ЭМГ, ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх арга хэмжээ зохион байгуулагдсан байна.
19.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчилах ажлыг зохион байгуулах	I-IV улирал	Эмнэлгийн тусламжийн газар	БТГ, НЭМУТ, ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ МӨАУМХ, МСЭМХ	Бүх төрлийн мэдээллийн хэрэгслэлээр ЭМАНШТУ, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчилсан байна.

20.	Уушигны хатгалгаа өвчний эсрэг Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг улсын хэмжээнд нэвтрүүлэх	I-IV улирал	Нийгмийн ЭМГ ОНХТШУХ	ЭТГ, ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	Дархлаажуулалтын хамралт 95 хувьд хүрсэн байна.
21.	Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины нэг тунгаар дархлаажуулах	I-IV улирал	Нийгмийн ЭМГ ОНХТШУХ	ЭТГ, ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	Дархлаажуулалтын хамралт 95 хувьд хүрсэн байна.
22.	Дархлаажуулалтын хамралтын цахим програмыг сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлэх	II-IV улирал	Нийгмийн ЭМГ	ЭМЦМХ, ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	Хамралтын програм нэвтэрсэн байна.
23.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд ХБӨ-ний тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх	I-IV улирал	Нийгмийн ЭМГ	Техникийн ажлын хэсэг, НЭМҮТ, СХДЭМТ, Дархан-Уул аймгийн ЭМГ	Сонгогдсон 2 эрүүл мэндийн анхан шатны байгууллагад хэрэгжүүлсэн байна.
24.	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах	I-IV улирал	Нийгмийн ЭМГ	СЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	Эмч, мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх ур чадвар нэмэгдсэн байна.
25.	Сүрьеэгийн тандалт, илрүүлэлтийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэх	I-IV улирал	Нийгмийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, МӨАУМХ, МСЭМХ Глобал сан	Сүрьеэгийн илрүүлэлтийн хувь нэмэгдэнэ.
26.	Гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналтын чанар, хүртээмжийг сайжруулах замаар тэмбүүгийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх	I-IV улирал	Нийгмийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, МӨАУМХ, МСЭМХ Глобал сан	Тэмбүү, ХДХВ-ийн илрүүлэлт, эмчилгээний үр дүн сайжирч, тэмбүүгийн тэмбүүгийн тохиолдол буурсан байна.
27.	Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах арга зүйн дэмжлэг үзүүлэх	I-IV улирал	Нийгмийн ЭМГ	БТГ, ЭМДБХ, ЭМДЕГ Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага	Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн байна.
28.	Гамшиг, пийлимийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүгийн эрсдлийн нөөцийн санг эрүүл мэндийн анхан шатны байгууллагын түвшинд бий болгох	I-IV улирал	Нийгмийн ЭМГ ОНХТШУХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрсдэлийн нөөцийн сантай болсон байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

29.	Жирэмсний хяналтын бүртгэл мэдээллийг цахимжуулж, нэрийн хяналтыг нэвтрүүлэх	I-IV улирал	ЭТГ	ЭМЦМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Жирэмсний хяналтын бүртгэлд цахим програмыг нэвтрүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийг нэрээр хянадаг болсон байна.
30.	ХӨЦМ-ын сургалтыг зохион байгуулж, нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн хяналтыг сайжруулах	I-IV улирал	ЭТГ	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Сургалт зохион байгуулагдсан байна.
31.	"Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" төслийг 2019 онд сонгогдсон өрх, сумын эрүүл мэндийн төвд хэрэгжүүлэх	I-IV улирал	ЭТГ	ХШУДАГ, ЭУТГ, БТГ, ЭМХТ, ДЭМБ, аймаг, нийслэлийн ЭМГ	"Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" төсөл шинээр 16 СЭМТ, 4 ӨЭМТ-д хэрэгжсэн байна.
32.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн магадлан итгэмжлэлд хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх	I-IV улирал	ЭТГ	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн анхан шатны байгууллагын тоо
33.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах сонгон шалгаруулалтад хамралтын хувийг нэмэгдүүлэх	I-IV улирал	ЭМДБХ	БТГ, ЭТГ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	ЭМД сангаас санхүүжилт авах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн тоо нэмэгдэнэ.
34.	Жирэмсэн болон хөхүүл эх, 6-23 сартай хүүхдийн А, Д аминдэм, олон найрлагат бичил тэжээл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх эм, хэрэгсэлийн хангалтыг нэмэгдүүлэх	II -IV улирал	ЗЗСХ	БТГ, ЭТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	Жирэмсэн болон хөхүүл эх, 6-23 сартай хүүхэд А, Д аминдэм, олон найрлагат бичил тэжээл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд ЖХЭХ-ээр бүрэн хангагдана.

Өрхийн эрүүл мэндийн тогтолцоонд шилжсэний 20 жилийн ойд зориулсан арга хэмжээ

35.	Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үүсч хөгжсөний 20 жилийн ойд	III улирал	БТГ	ТЗУГ, ЭТГ, Нийслэлийн ЭМГ, МӨАУМХ	Хурал зохион байгуулагдсан байна.
-----	--	------------	-----	-----------------------------------	-----------------------------------

	зориулсан хурлыг зохион байгуулах								
36.	"Өрхийн анагаах ухааны хөгжил, тулгамдсан асуудал" сэдэвт олон улсын онол практикийн бага хурал зохион байгуулах	III улирал	БТГ	Нийслэлийн ЭМГ, МӨАУМХ, АШУУИС	Онол практикийн бага хурал зохион байгуулагдсан байна.				
37.	Өрхийн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах	II улирал	ЭТГ	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, МӨАУМХ	Өрхийн эмч, сувилагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтны дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулагдсан байна.				
38.	Иргэдэд чиглэсэн Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах (Хөдөлгөөн –эрүүл мэнд аян, эрүүл хооллолт клубыг баг, хороо бүрт байгуулах)	I-IV улирал	Нийгмийн эрүүл мэндийн газар	ЭТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ, МӨАУМХ, МСЭМХ	Зохион байгуулсан ажлын тайлан				

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад хийх хөрөнгө оруулалт

39.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд компьютер хуваарилах ажлыг зохион байгуулах	II- IV улирал	БТГ	ЭМЦМХ, Дэлхийн банкны "Цахим эрүүл мэнд" төсөл	Ий.түүлсэн компьютерийн тоо
40.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах	I-IV улирал	ЭЗСХОГ	ХОХ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Шинээр баригдаж, ашиглалтад орсон сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн тоо
41.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөл, их засвар хийх	I-IV улирал	ЭЗСХОГ	ХОХ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Засварт хийгдсэн болон өргөтгөл баригдсан сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн тоо
42.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж хуваарилах	I-IV улирал	ЭЗСХОГ	ХОХ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Шинээр нийлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо
43.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн машин олгох	II-IV улирал	ЭЗСХОГ	ХОХ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Олгосон түргэн тусламжийн машины тоо